

ФРЕЙДИЙН ПСИХОАНАЛИЗ БА ФЕМИНИСТ ОНОЛЫН ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ

М.Отгонбаяр- МУИС-ийн Философийн тэнхмийн дэд профессор

Товч утга: Феминизм ба психоанализын харилцааны түүх нэлээн хоёрдмол шинжтэй, нэг талаас арга зүйн хувьд феминист судалгаа нэлээд хэмжээгээр психоанализад тулгуурладаг, нөгөө талаас психоанализын суурь үзэл суртлын тавилтуудыг феминистүүд хүчтэй шүүмжилдэг.

Анхандаа феминистууд психоаналитик онол ба эмчилгээг шууд хүлээж аваагүй юм. Энэ нь эмэгтэйчүүдийн захирагдмал ба идэвхгүй байдлыг бэхжүүлэхийн тулд психоанализыг ашигладаг байсан түүхэн болон оршин байсан уламжлалтай холбоотой юм. Тухайлбал Симона де Бовуар, Бетти Придан, Кейт Миллет, Глория Стайнем нарын зэрэг феминистүүд психоанализ бол эмэгтэйчүүдийг дарамтлах нэг хэрэгсэл хэмээн буруутгасан байдаг.

XX зууны 70, 80-аад оны үеэс феминист онолчид эмэгтэй хүний бэлгийн мэдрэмж ба субъектив чанарын талаархи психоанализын үндэслэлүүдэд гол анхаарлаа хандуулж эхэлжээ. Психоанализ бол хүний психийг ухамсаргүйн хүрээнд шинжилдэг ч гэлээ тэр нь эмэгтэйчүүдэд тэдний амьдралын хувийн болон улс төрийн хэм хэмжээг ойлгоход тусалж болох юм хэмээн феминистүүд үздэгт учир нь байгаа юм. Эл чиглэлийг психоаналитик феминизм гэж нэрлэдэг ба энэ нь хувь хүмүүс, тэдний хоорондын болон нийгмийн харилцааны шинж чанарт ул мөрөө үлдээж байдаг далд психодинамикт буюу бидний сэтгэлгээ, сэтгэл хөдлөл, үйл хөдлөлийг хэлбэршүүлж байдаг ухамсаргүйн динамикт төвлөрч байдаг юм.

Фрейдийн үзлийн феминизмд үзүүлсэн нөлөө. Феминист онолд арга зүйн хүчтэй нөлөө үзүүлсэн психоанализын нэг гол төлөөлөгч бол З.Фрейд юм. Фрейдийн үзэл, бүтээлийг 1890-1920-иод оны үе, 1920-1940-өөд оны үе гэж хоёр хэсэгт хувааж болох бөгөөд эхний үед хүүхдийн бэлгийн мэдрэмжийн асуудалд гол анхаарлаа хандуулсан бол хоёр дахь үед хүйсийн ялгааны асуудлын судалгаанд түлхүү анхаарчээ.

Чухамхүү Фрейд л урьд өмнө яригдаж байгаагүй эмэгтэйчүүдийн феноменийг орчин үеийн соёлд оруулж ирсэн бөгөөд асуудлыг үл ухамсарлахуйн хэмжүүрүүдээр авч үзсэн бөгөөд эмэгтэй хүний субъектив чанар, бэлгийн мэдрэмж, үл ухамсарлахуй, хүйсийн адилсал зэрэг ойлголтуудыг гарган, тэдгээрээр дамжуулан психоаналитик тайлбарлалаа хийсэн юм. Ингэснээрээ эмэгтэйчүүдийн феномен бол соёлын гол үзэгдэл гэсэн феминист үндэслэлд хэрэг болсон ажээ.

Фрейд эхэн үедээ Эдипийн комплексод утга оноох байдлаар эмэгтэй хүний бэлгийн мэдрэмжийг тодорхойлжээ. Тухайлбал хүүхэд эсрэг хүйсийн эцэг эхдээ тачааддаг (Эдипийн комплекс)-ийг нь бяцхан Ганс хүүгийн тохиолдол⁸² /"Таван настай хүүгийн фоби өвчний анализ", 1909 он/, мөн Дора-гийн тохиолдол⁸³ /Истери өвчний анализ", 1905 он/ -оор баталжээ.

Фрейд 1905 онд бичсэн "Бэлгийн мэдрэмжийн онолын талаархи гурван судалгаа" бүтээлдээ жендерийн бэлгийн мэдрэмж тэгш хэмтэй байх тухай санааг анх няцаасан юм. Фрейд энэхүү бүтээлдээ перверси /гажуудал/-ын тухай асуудлыг авч үзсэн ба бэлгийн мэдрэмжийн тухайд перверси бол хэзээ ч тогтсон зорилготой байдаггүй гээд үүндээ үндэслэн хэвийн ба хэвийн биш гэсэн шалгуураар хүний бэлгийн мэдрэмжийг хуваах

⁸² Фрейд З. Анализ фобии пятилетнего мальчика //Психология бессознательного. М., Просвещение, 1989. сс 39-121.

⁸³ Фрагмент анализа истерии (История болезни Доры) //Избранное. Ростов на Дону.1998. сс 177-336

ёсгүй. Бэлгийн мэдрэмж бол бүхэллэг, полиморф нарийн нийлмэл бүтэцтэй гэж үзсэн. Ийм арга зүйн үүднээс адилслын (identity) жендерийн параметрийг авч үзэхдээ үнэлгээний шалгуураас татгалзахад хүрч буй юм. Чухамхүү эл бүтээлдээ Фрейд Эдипийн өмнөх үе шатан дахь "хүсэл"-ийг (хүүхэд эхийнхээ хөхийг хүсэх нь нэгдмэл бүхэл объект руу хандаж байгаа хэрэг биш) хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь аажимдаа феминист судлаачдын эмэгтэй хүний хүслийн талаархи психоаналитик баримтлал дахь үндсэн зүйл нь болсон юм. Тухайлбал Дора жендерийн адилсалын эрэгтэй хэв маягтай байсан нь Фрейдийг хүслийн гетеросексуаль бүтэц дэх "төрөлх шинж", "хэвийн байдал" гэх мэт ойлголтуудад эргэлзэхэд хүргэж улмаар маш нарийн нийлмэл полиморф бүтэц хэмээн үзэхэд хүргэсэн байна.

Фрейд эхний үедээ фантази, дур хүсэл, хэлний алдаанд анализ хийх явцдаа хүүхдийн адилслын бүтэц дэх жендерийн ялгааны онцлогийг тодорхойлохыг оролдсон юм. Ингэхдээ жендерийн ялгаа бол төрөлх биш, харин Эдипийн комплексийн шатанд бүрэлддэг, учир нь хүүхдийн полиморф бэлгийн мэдрэмж эрэгтэй, эмэгтэй аль нэгэн адилсалд татагддаг, ингэхлээр Фрейдийн үзлээр адилслын аль нэгэн хэв маягийг олж авах нь хүүхдийн анхдагч полиморф адилсалд бусад шинжүүд давамгайлан орж ирэхтэй холбоотой болж буй юм. Психоанализын жендерийн адилслын психик бүтцийн тухай санаа нь феминист философийн нэг үндэслэл болдог. Тодруулбал, патриархат соёлын чухам ямар ямар нийгмийн үзэгдлүүд нь жендерийн ялгаатай субъектив чанарыг тогтоож байна вэ? зэрэг асуултанд хариулах боломжийг олгодог. Ийнхүү психоаналитик онол нь ухамсар, хэл, хэлний утга, "эрэгтэй" ба "эмэгтэй" гэх мэт үзэгдлүүдийг тайлбарлахад хэрэгтэй ойлголтуудыг бүтээсэн юм. Үүний зэрэгцээ феминистүүд социаль болон соёлын хэм хэмжээнд жендерийн стереотип хэрхэн нөлөөлж буй байдлыг ойлгох зорилго тавихдаа Фрейдийн боловсруулсан хүний психосексуаль хөгжлийн загварыг эмэгтэй хүний бэлгийн мэдрэмж, эмэгтэйд шинж, социум дахь эмэгтэй репрезентацийн асуудлыг ойлгох үндсэн загвар, түлхүүр болгосон.

1920-иод оныг хүртэл Фрейд хүслийн бүтэц бол зарчмын хувьд хоёрдмол шинжтэй гэх буюу "бисексуаль чанар" хэмээх ойлголтоор дамжуулан эмэгтэй хүний үл ухамсарлахуйг тодорхойлж байлаа. Харин 1924 онд гаргасан "Эдипийн комплексийг шийдвэрлэсэн нь" хэмээх бүтээлдээ кастрацийн комплексийн тухай санааг дэвшүүлжээ. Фрейд эрэгтэй, эмэгтэй хүний ялгааг кастрацийн комплекс хөвгүүд, охидод ялгаатай илэрдэгээр дамжуулан тайлбарлахдаа, "кастрацияс айх биш харин пенист атаархах байдлаар" энэ комплекс охидод илэрдэг хэмээн үндэслэжээ.

Фрейдийнхээр өсөн том болж буй эрэгтэй хүүхэд эмэгтэй фаллосыг фантазалж, өөрийн кастрацийн айдсыг үгүйсгэхийг оролддог, хэвийн тохиолдолд эрэгтэй хүүхэд өөрийг нь айлган сүрдүүлж буй кастрацийн айдас бол охид ч бас пенисгүй байж болох ба хүний ертөнцөд үнэхээр пенисгүй хүн байдаг хэмээн итгэхэд хүрч, өөрийн мэдрэмжийг аажмаар хүлээж авдаг аж. Фрейдийн хувьд эрэгтэй хүүхдийн сексийн сонирхол болон сониуч зан бол хүйсүүдийн хоорондох гениталийн ялгаа болон хүүхэд хаанаас төрдөг тухай оньсого мэт байдаг зүйлтэй холбоотой. Гэтэл эмэгтэй хүүхдийн хувьд асуудал өөр байдаг байна. Эмэгтэй хүүхэд дүгнэлт, шийдвэрээ маш хурдан гаргадаг бөгөөд өөрийнхөө гениталийг хараад пенисгүй гэдгээ ойлгоод пенистэй болохыг хүсэж өөрийнхийгөө сорви мэт дорд байдлаар хүлээж авдаг. Улмаар хоёр хүйс хоёулаа эмэгтэйчүүдийг жигшин зэвүүцдэг байна. Эрэгтэй хүүхэд эмэгтэй хүнийг гажуудсан хүн гэж үздэг бол эмэгтэй хүүхэд ч мөн адил эмэгтэй хүнийг дорой хөгжилтэй хэмээн эрчүүдийн үзлийг хуваалцаж эхэлдэг. Эрэгтэй хүүхдээс ялгаатай нь эмэгтэй хүүхдийн сексийн анхны сонирхол хүүхэд хаанаас төрдөг тухай гэхээс илүүгээр гениталийн ялгаан дээр төвлөрдөг⁸⁴. Ийнхүү Фрейдийн хувьд кастраци бол эмэгтэй хүний психологид чухал асуудал байдаг бөгөөд эмэгтэй хүүхдэд Эдипийн комплекс эрэгтэй хүүхдэд байдаг шиг хэзээ ч туйлын байдаггүй гэж үзжээ.

⁸⁴ Stephen Frosh. *Sexual Difference: Masculinity and Psychoanalysis*, 1994. p.25.

“Эдипийн комплекстой харьцуулахад кастрацийн комплекс нь хүйсийн ялгаатай илүү холбоотой. Хөвгүүд эхийгээ хүсэх үедээ эцгийгээ өрсөлдөгч мэтээр зайлуулахыг хүсдэг гэх Эдипийн комплекс нь фаллосын бэлгийн мэдрэмжээс эхэлдэг. Гэтэл кастрацийн айдас нь энэ байдлаас гарахад хүргэдэг, өөрөөр хэлбэл Эдипийн комплекс нь пенисээ алдах айдсын нөлөөгөөр хамгийн жирийн тохиолдолд үндсээрээ замхран арилж түүний оронд хатуу чанд Суперэго гарч ирдэг. Гэтэл охидод үүний эсрэг зүйл болдог, кастрацийн комплекс нь Эдипийн комплексийн бэлтгэл болж, түүнийг үгүй болгохын оронд харин пенист атаархах нь эхтэйгээ харилцаагаа таслахад хүргэдэг. Кастрацийн айдас арилснаар хөвгүүдэд Эдипийн комплексыг даван туулах сэдэл үүсдэг бол охид тодорхойгүй урт хугацаагаар тэрхүү айдасын нөлөөн дор байж нэлээн хожуу түүнээс бүрэн ангижирдаг ажээ. Энэ нөхцөл байдал дахь Суперэго-ийн үүсэл хэлмэгдэж, тэр нь бие даасан соёлын утга бүхий болох тэр түвшиндээ хүрч чаддаггүй бөгөөд үүний үр дагаварыг эмэгтэй хүний жирийн хэмээгддэг зан төлөвтэй холбож тайлбарладагт феминистүүд дургүй байдаг юм”⁸⁵ гэж Фрейд бичжээ.

Фрейд “Ханамжийн зарчмын гадна” хэмээх бүтээлдээ: “хүний хүйсийн төлөвшил дэх тодорхойлогч зүйл бол охид, хөвгүүдийн анатомийн онцлог биш, харин хүйсийн байдлаас нь үл хамаарах, субъектын уг чанарт тогтвортой байдаг дотоод айдасын байдал”⁸⁶ хэмээн үзсэн нь кастрацийн комплексын асуудлаархи түүний тайлбарлалын өвөрмөц шинжийг харуулж байна. Энэ нь хожим феминистүүд хувь хүний хүйсийн адилсал бол биологийн шинжээр биш, харин нийгмийн шалтгаантай хэмээн тайлбарласны арга зүйн үндэслэл болж байна.

Фрейд эмэгтэй хүний субъектив чанарын бүтцийг нарциссизмын бүтэцтэй холбож тайлбарлахдаа хүний “Би”-г “бодит Би” ба “нарциссист Би” гэсэн хоёр үндсэн хэв маягт хувааж үзээд “бодит Би” бол байгалийн хэмжүүрүүдээр хэмжигддэг, харин “нарциссист би” нь биологийн биш үр дагавар гэдэг. Ингэхдээ Фрейд эмэгтэй хүний субъектив чанарын бүтэц бол бодит “би”-тэй холбоотой биш харин нарциссизмын бүтэцтэй холбоотой гэжээ. “Нарциссист би” бол либидогийн үндэс мөн. Өөрөөр хэлбэл либидо нь эсвэл объект-либидо болж хувирдаг, эсвэл “би”-ийн дотор нэвчиж “би-либидо” болдог, сүүлчийн тохиолдолд нарциссист “би”-ийн бүтцийг тогтоодог ажээ.

Фрейд сонгодог философийн субъект хэмээх хийсвэр ойлголтын оронд тодорхой психологийн бодит байдал болох “эрэгтэй” ба эмэгтэй”-чүүдийн харилцааны өвөрмөц онцлогийг гаргаж тавьсан нь феминистүүдэд арга зүйн ач холбогдолтой юм. Ингэхдээ тэрээр анх удаа субъектив чанарын бүтцэд адилслын жендерийн параметруудыг гаргаж өгчээ. Хувь хүний адилсал нь гэр бүлд төлөвшдөг учраас гэр бүл дэх жендерийн харилцааны психологийн контекстыг судлах хэрэгтэй гэж тэрээр үзсэн.

Гэхдээ Фрейдийн психоанализад эмэгтэй хүний субъектив чанар бол Бусад-ын байр сууринаас хамааралтай байгаа бөгөөд тэр нь автоматаар буй болж буй тохиолдолд ч Бусад (эрэгтэй хүн/эцэг) анхдагч болж байгаа нь эмэгтэй хүний субъектив чанар болон соёл дахь эмэгтэй хүний феномен үүсэх гол нөхцөл бол Бусад мөн.

Феминистүүдийн тайлбар: Английн психоаналитик, социалист феминист Жулэт Митчелл “Феминизм ба Психоанализ” хэмээх бүтээлдээ Фрейдийн онол феминизмд хэрхэн нөлөөлсөн талаар тодорхой авч үзжээ. Тэрээр Фрейдийн анализад сэтгэцийн болоод биологийн хоёр ялгаатай тайлбар байгааг онцлоод Фрейдийн психоанализыг хүний бэлгийн мэдрэмжийн гарвал ба бэлгийн мэдрэмжийн хөгжлийн тухай онол гэсэн хоёр хэсэгт хуваан үзжээ. Психоаналитик онолын тулгын чулуу болох энэ хоёр үндсэн зарчим нь хэдийгээр Фрейдийн онолын хамгийн их маргаантай санаанууд боловч патриархи соёл дахь эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцааны талаарх феминист тайлбарт түлхүүр санаа болж өгдөгөөрөө феминист философид чухал нөлөөтэй юм.

⁸⁵ Фрейд З. Женственность //Введение в психоанализ. Лекции. М., 1991. С 369.

⁸⁶ Фрейд З. По ту сторону принципа удовольствия //Психология бессознательного. М., 1989. С 382.

Эмэгтэй хүний асуудлаарх Фрейдийн үзлийг олон феминистүүд шүүмжилдэг. Харин Митчелл эмэгтэй хүний сэтгэл зүйн асуудлаарх Фрейдийн анализ бол патриарх нийгэм дэх эмэгтэй хүний статусыг ойлгоход чухал хэрэгтэй бөгөөд ингэж ойлгохгүйгээр нийгэм дэх эмэгтэйчүүдийн үүргийг зохистойгоор өөрчлөх боломжгүй гэж гэж үзсэнээрээ Фрейдийг шүүмжилдэг феминистүүдээс ялгардаг. Фрейд бол эмэгтэйчүүдийг доорд зиндааны, идэвхигүй, захирагдмал хэмээн үзсэн гэдэг феминистүүдийн шүүмжлэлээс ялгаатай нь Фрейд бол эмэгтэйчүүдийн талаархи өөрийн судалгааны дүнг л харуулсан болохоос биш тэдний нийгмийн үүргийг нь заагаагүй хэмээн удаа дараа хэлж байснаараа Митчеллийн үндэслэл онцлог юм.

Жулет Митчелл “бэлгийн мэдрэмжийн тухай Фрейдийн онол бол хүний бэлгийн мэдрэмжийг уг чанараараа гетеросексуаль, гениталийн, нөхөн үржихүйн биш шинжтэй гээд энэхүү гетеросексуаль буюу гениталийн бэлгийн мэдрэмж нь хөгжлийн урт удаан, нарийн процессын үр дүн болохын хувьд нэг бололцоот үр дагавар нь юм гэж үзсэнээрээ феминизмд давуу талтай юм” хэмээн үнэлсэн байдаг. Фрейдийн хувьд бэлгийн мэдрэмж бол нөхөн үржихүйгээс илүү дээр зүйл бөгөөд нөхөн үржихүйн шаардлага төдий зүйл эсвэл урьдаас тогтоогдсон мөн чанар биш байсан гээд бэлгийн мэдрэмжийг биологийн хэрэгцээ, инстинкт гэхээсээ фантаз болон утгын бүтцийн үр дүн хэмээн Митчелл үздэг. Тэрээр “Гэр бүлийн тухай үзлийг эргэн үзэх хэрэгтэй бөгөөд чухам энд л эмэгтэй хүний захирагдмал байдлын психологи төлөвшдөг ба нийгэм, эдийн засгийн хувьд эмэгтэй хүнийг дарлах явдал гэр бүлд л легитимчлэгддэг” хэмээн үзээд нийгмийн харилцааны контексоор л эмэгтэй хүний Его-ийн тухай ярьж болно гэж үздэг.

Фрейдийн онолыг судалсан феминистүүд дотроос Люси Иригарэй кастрацийн комплексын үр дүн болох эмэгтэй хүний сексуаль адилслын тухай үзлийг нь авч үзсэнээрээ онцлог юм. Фрейдийн үзлээр эмэгтэй хүүхэд пенисгүйгээ ойлгоод түүгээр дутагдаж, хүссэнээс үүдсэн сэтгэл хөдлөл нь түүнийг нийгмийн патриархид захирагдахад хүргэнэ. Иригарэй “юу ч биш”-ээр дутагдсан гэдэг үүднээс эмэгтэй хүний бэлгийн мэдрэмжийг авч үзсэн Фрейдийн арга зүйг судалсны үндсэн дээр “юу ч биш”-тэй байна гэдэг нь “юу ч үгүй, ахуйгүй, мөн үнэнгүй”⁸⁷ байна гэсэн үг гэж дүгнэсэн. Эндээс үзвэл Иригарэйн энэ үндэслэл нь “патриархи систем дэх эмэгтэй хүний үүргийг кастрацийн комплекс тодорхойлдоггүй юм бол эмэгтэй хүнийг “юу ч биш” гэдгээр тодорхойлсон тодорхойлолт нийгэм дэх эмэгтэй хүний үүрэг, дүрслэлийг илүү харуулна гэсэн дүгнэлтэд хүргэнэ гэж үзжээ.

Психосексуаль хөгжлийн тухай Фрейдийн онолыг феминистүүд хүчтэй шүүмжилдэг. Хэдийгээр психоаналитик психологичдын дотор Фрейдийн онол алдартайд тооцогддог ч сексист хэмээн шүүмжлэгдэх нь олонтаа. Фрейдийн онолууд голдуу түүний өөрийн анализ, интроспекцийн үр дүн байснаас гадна асуудлыг эрэгтэй хүний нүдээр харж байсан нь феминистүүд төдийгүй жендерийн онолчдын томоохон шүүмжлэлийн бай болдог байна. Тухайлбал, Фрейд эмэгтэй хүүхэд психосексуаль үедээ эрэгтэй хүнд хандах “пенист атаархах” хандлагаар өсч том болдог гэж үзсэн. Кэрин Хорни үүнд нь хариу болгож “пенист атаархах” гэдгийн оронд “эрх мэдэлд атаархах” гэсэн нэр томъёо хэрэглэн эмэгтэй хүүхэд эрэгтэй хүний эрх мэдэлтэйд атаархаж өсч том болдог гэж үзсэн. Гэтэл Фрейд бяцхан охид пенист атаархдаг ч энэ хүсэл нь эмэгтэй хүний цаашдын хөгжилд хэрхэн нөлөөлдөг талаар нарийн тайлбарлаагүй байна. Харин Хорни Фрейдийн тэрхүү үндэслэлд тулгуурлан эмэгтэй хүний зан авирыг тодорхойлох биологийн хүчин зүйлээс илүүтэйгээр хүрээлэн буй орчны болоод нийгмийн нөхцөлд анхаарал хандуулсан байна. Тэрээр мөн Фрейдийг эго-д хангалттай тайлбар хийгээгүй гэж шүүмжлээд эмэгтэй хүний сэтгэцийн хямрал (disturbance) нь бэлгийн мөн чанараас болж буй хэрэг биш, харин саадтай өсөлт хөгжлөөс үүдсэн бухимдлаас гадна тэдний

⁸⁷ Irigaray, Luce. "Another 'Cause'--Castration." *Feminisms*. Ed. Robyn R. Warhol and Diane Price Herndl. New Brunswick: Rutgers Univ. Press, 1991. 405-406.

чадвар, бололцоог үгүйсгэсэн нийгмийн дарамт болон материаллаг саадаас үүдэлтэй⁸⁸ хэмээн үзсэн. Түүгээр ч барахгүй Хорни "пенист атаархах" гэдэгт сөргүүлэн "эрэгтэй хүн эмэгтэй хүний хүүхэд төрүүлэх чадварт атаархдаг" гэдгийг харуулахаар "умайд атаархах" гэсэн нэр томъёог гаргаж ирсэн. Тэрээр энэхүү санаагаа 1932 онд бичсэн "Эмэгтэй хүнээс айхуй" (The Dread of Woman) бүтээлдээ илэрхийлжээ.

Мөн тэрээр эрчүүдийн эмэгтэй хүнээс айх айдсыг олон янзаар маш тодорхой гаргажээ. Тухайлбал, эрэгтэй хүний гомосексуаль шинжийг эмэгтэй хүний гениталиас зугтах буюу түүний оршихуйг үгүйсгэх гэсэн хүсэл гэж үзсэн. Энэ үүднээсээ тэрээр Фрейдийг энэ айдас түгшүүрийг тайлбарлаж чадаагүй хэмээн шүүмжилжээ.

Хорни бэлгийн бойжилтын үед хэвийн эрэгтэй хүүхэд үтрээний талаар аль хэдийнэ ухамсартай мэдлэг олж авсан байдаг боловч түүнийг ямар нэгэн ид шидтэй нууц зүйл хэмээн айдаг, энэхүү айдас нь өсч том болсон хойно ч үргэлжилж болно хэмээн үзсэн. Тэрээр эмэгтэй хүний бэлгийн мэдрэмжийн талаар бичсэн Фрейдийн өгүүлэлд анализ хийх явцдаа тэрхүү айдас түгшүүрийн уг үндэс, шинж чанар болон эрэгтэй хүүхэд эхтэйгээ харилцах харьцааг бүрхэгдүүлдэг хүчин зүйлсийг илрүүлэн гаргахыг оролджээ. Ийнхүү түүний үзлээр тэр айдас, түгшүүр хүүхдийг бүр нялх байхад эх нь анх түүний зөн билгийн үйл ажиллагааг хоридогоос эхэлдэг аж. Үүнийг Митчеллийн үзэлтэй харьцуулбал: бяцхан охин хувь заяагаа рациональ байдлаар танин мэдэж шийддэг ба эх болох нь идэвхитэй бүрэлдэхүүнүүдээсээ урган гардаг гэж үзсэн. Түүнчлэн эх нь хүүхдэд зөвхөн субординаци мэтээр ойлгогддог. Харин Хорни хүйсийн хоорондох анатомийн ялгаа эрэгтэй ба эмэгтэй хүүхдийн хувьд эрс ондоо нөхцөл байдалд хүргэдэг гэсэн. Эмэгтэй хүүхэд өөрийн гениталийг эцгийнхээ пенист хэтэрхий жижигдэнэ гэдгийг мэддэг ба эцгийн пенисийг хүсэх түүний хүсэл биелбэл түүний гениталь гэмтэж, үгүй болох байх гэсэн айдастай байдаг. Нөгөө талаас, эрэгтэй хүүхэд пенис нь эхийн генитальд хэтэрхий жижигдэхийг зөнгөөрөө мэдэрч өөрийн дутуу байдал, гологдож тохуурхагдахаас айдаг⁸⁹. Ийнхүү Хорни хөвгүүдийн айдас охидынхоос өөр гээд эрэгтэй хүүхдийн кастрацийн айдсын тухай Фрейдийн тайлбарыг үгүйсгэн эмэгтэйчүүдээс айх эрэгтэй хүүхдийн айдас бол кастрацийн айдас огтхон ч биш, харин түүний өөрийгөө хүндлэх сэтгэлд тулгарсан аюул, заналхийллийн илрэл хэмээн үзсэнээрээ сонирхолтой юм.

Америкийн феминист эмэгтэй Кейт Миллет 1970 онд бичсэн "Хүйсийн улс төр" (Sexual Politics) зохиолдоо Фрейдийн үзлийн биологийн болон анатомийн детерминизмийг нарийвчлан задлан шинжилж, шүүмжлэлтэй хандсан. Тэрээр Фрейд пенисийг клитороос илүүд үзсэнийг шүүмжлэн "Том учраас илүү сайн гэж үү? Тэгвэл эрэгтэй хүн хөхгүй байдаг нь ч гэсэн яагаад сэтгэлийн шаналал байж болохгүй гэж"⁹⁰ хэмээн ёжтойгоор хэлсэн байдаг. Тэрээр психик зүйлийг биологийн зүйл рүү оруулан тайлбарлаж болохгүй бөгөөд биологийн хувьд дутуу гэдэг үндэслэлээр эмэгтэй хүнийг тайлбарласан, эмэгтэй хүний субъектив чанарыг "Бусад"-аар дамжуулан тодорхойлж болохгүй хэмээн Фрейдийг шүүмжилсэн. Харин хэлний болон үл ухамсарлахуйн баримтлал нь Фрейдийн психоаналитик онол дахь хамгийн дэвшилтэт хэсэг нь бөгөөд чухамхүү энэ нь соёл дахь эмэгтэй хүний феноменыг тайлбарлахад чухал байсан гэж Миллет үнэлжээ.

Феминист арга зүйн үүднээс Фрейдийг шүүмжилсэн бас нэгэн Суламифи Файерстоун "Хүйсийн диалектик" (The Dialectic of Sex) хэмээх бүтээлдээ патриархи нийгэм дэх эмэгтэй хүний байдал нь түүний психосексуаль бүтэцтэй холбоотой, эмэгтэй хүүхэд эрэгтэй хүүхэдтэй харилцахдаа өөрийн дорой байдлыг мэдрэх нь хүүхдийн

⁸⁸ Sneja Marina Gunew, Sneja Gunew. Feminist knowledge: Critique and Construct, 1990. p.181.

⁸⁹ Wendy Kolmar, Frances Bartkowski. Feminist theory. Mountain View, California: London and Toronto. 2000. p.129.

⁹⁰ Sneja Marina Gunew, Sneja Gunew. Feminist knowledge: Critique and Construct, 1990. p.182.

туршлагаас ажиглагдаж болох энэ баримтын логик үр дүн. Ингэхлээр зайлах аргагүй нийгмийн бодит байдлаас үүний шалтгааныг авч үзэх хэрэгтэй гэж үзсэн. Үүгээрээ тэрээр үл ухамсарлахуйн тухай ойлголтыг үгүйсгэсэн.

Психоанализ нь уламжлалт философийн рациональ чанар дахь "нэгдмэл өөрийгөө төлөөлсөн субъект"-ын асуудлыг өөрөөр гаргаж тавьсанаараа патриарх соёлын нөхцөлд эмэгтэй ба эрэгтэй гэсэн параметраар ялгаран, жендерээр нөхцөлдөн бүтэцжсэн субъектив чанарын үзэгдэлд соёлын үндэслэл өгөх боломж олгосон юм. Мөн психоанализ нь феминизмийн онолын адилаар психикийн бүтэц, хүслийн бүтэц, хэл ба репрезентацийн уг чанар, бэлгийн мэдрэмж ба субъектив чанар гэх мэт орчин үеийн феминист философийн тулгамдсан чухал асуудлуудыг анх дэвшүүлснээрээ чухал юм.

Abstract: Feminism is based on psychoanalysis methodologically in one hand and on the other hand it criticizes installations of psychoanalytical point of views. Though psychoanalysis analyses human psyche in domain of Id, feminists view that it may help to understand private and political norm of woman's life. Women's subjectivity in Freud's psychoanalysis defend on "other's" point of view and even if it is created automatically, the fact that "other" (man/father) is forerunner makes "other" the base in formation of subjectivity of women and female phenomena in culture. Psychoanalysis made it possible to give cultural accounts to phenomena of subjectivity that is being structured by genders and being categorized into male and female parameters in patriarch cultural environment by taking the matter of "collective and self represented subject" in the rational nature of traditional philosophy from different perspective.

Also like theory of feminism, psychoanalysis is important as it brought the vital issues structure of psyche, and desire, nature of language and representation, sexuality and subjectivity.